

ОРЧИН ЦАГИЙН ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ОРШИХҮЙН ТАЛААРХИ ФИЛОСОФИ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Түлхүүр үс: хүйс, дагавар хүйстэн, хүйсийн тухай хэвшмэл бодол, жинхэнэ эмэгтэй, эршүүд эмэгтэй

"Орон гэр бол эмэгтэй хүний ертөнц, харин ертөнц бол эр хүний орон гэр" гэсэн эртний уг байдаг. Энэ бол хүн төрөлхтний түүхийн 2000 гаран жилийн туршид тогтсон хүйсийн стереотипийн бодит дүр зургийг илтгэж байгаа юм гэхэд хэн ч маргахгүй биз ээ. Тэгвэл бидний амьдарч буй эрин үе бол "эмэгтэй хүн" эрэгтэйчүүдийн ертөнц рүү нэвтэрч тавиж байгаа шилжилтийн меч. Улс орон бүрт, үндэстэн болгонд энэ үйл явц өөр өөрийнхөөрөө янз бурийн хэлбэрээр явагдаж байгаа боловч эрэгтэй хүн урьдын адил "тодорхойлогч", "давуу" шинжээ баттай хадгалсан хэвээр байгаа билээ. Эмэгтэй хүн эр хүний ертөнцөд орж ирсэн болохоор эмэгтэйн хувьд гэнэтийн үл ойлгогдох, цоо шинэ асуудлууд ар араасаа хөврөн гарсаар байна. Практик сэтгэл зүйд эрэгтэй эмэгтэй хүнийг "хоёр өөр гаригийн хүмүүс дэлхий хэмээх гариг дээр ирж, хамтран амьдардаг" хэмээн их оновчтой томъёолсон нь ч бий. Үүссэн бүх асуудлууд дотроос хамгийн гол, зайлшгүй асуудал нь эмэгтэйн мөн чанарын тухай сэдэв юм гэж орчин үеийн жендерийн онолууд нэгэнт хүлээн зөвшөөрчээ.

Эрэгтэй болон эмэгтэй хүний жинхэнэ мөн чанар болох "жинхэнэ эр хүн"-ий болон "жинхэнэ эмэгтэй"-н шинж нь нийгмийн утгаараа ч өнө эртнээс улбаатай уламжлалт соёлын гүнд ч, сансар огторгуйн, байгалийн зохицлоороо ч эрс ондоо зүйлүүд гэдгийг сэтгэгчид онцлон тэмдэглэсээр иржээ.

Сүүлийн 30 гаруй жил барууны шинжлэх ухаан, утга зохиолд "хүйс"-ийн асуудлыг түүхэн сэдэв хэмээн авч үзэж байна.

Уг нь хүйсийн судалгаа нийгмийн амьдрал дахь хүйсийн зохицлоогоог хангах зорилтоос үүдэн XX зууны судалгааны тэргүүлэх салбар болон хөгжиж иржээ. Харин XXI зуун бол эрэгтэй эмэгтэй хүмүүс хамтран "түүх"-ээ бүтээх эрин үеийн эхлэл боллоо гэж жендер судлал үзэж байгаа юм.

Эмэгтэйн мөн чанарын сэдэв нь онолын судалгааны төдийгүй философиийн нэн чухал байж иржээ. "Мөн чанар"-ын асуудал зөвхөн хүний мөн чанар, хүний ахуйн асуудлын хүрээнд тавигдана гэж экзистенциалист философид үздэг билээ. Энд Францын философич Ж.П.Сартрын холбогдох

философи үзлийг онцлох шаардлагатай байдаг. Түүний хүний ахуйг феноменологи арга зүйгээр задлан шинжилсэн "Ахуй ба цаг хугацаа" гэдэг томоохон бүтээл байдаг. Уг бүтээл дэх холбогдох үндэслэлүүдийг нь эмэгтэй хүний оршихуйн онцлог, эмэгтэйн мөн чанарыг судлан шинжлэх арга зүй болгон бичсэн Симона де Бовуарын "Дагавар хүйстэн" бүтээл эмэгтэйн мөн чанарыг авч үзсэн философийн анхны эх сурвалж төдийгүй орчин үеийн жендер судлалын онолын үндэс болдог юм. Симона де Бовуар эрэгтэй эмэгтэй хүмүүс хоорондын харилцааны экзистенциаль бүтцийг гаргахдаа эмэгтэй хүн буюу "дагавар хүйстэн" хүний мөн чанарыг судлан шинжилсэнээрээ онцлогтой байсан юм. "Хэн нэг эрэгтэй хүний зүгээс над руу: "та эмэгтэй хүн болохоороо л ингэж бодож байгаа юм" гэж хандахад би их цухалдаж бухимддаг байлаа. Гэвч би "Яагаад гэвэл миний бодож байгаа зүйл үнэн болохоор би үүнийг хэлж байна" гэсэн цорын ганц өөрийгөө хамгаалах үндэслэлийг би маш сайн мэддэг байснаараа өөрийнхөө оршихуйн үнэнийг мэдэрдэг байлаа." Харин: "Та эрэгтэй хүн болохоороо л ингэж бодож байгаа юм" гэж хариулж болохгүй байсан юм. Учир нь, эрэгтэй хүн байна гэдэг ямар нэг "өвөрмөц" утга агуулгатай зүйл биш болохоороо л тэр. Эрэгтэйчүүд хэзээ ямагт өөрийнхөөрөө, тэд ямагт зөв, харин бүх бурууг зөвхөн эмэгтэйчүүд л хийдэг гэсэн хандлага бүр эрт үеэс тогтож, эр хүн ямагт "хүн"-ий оршихуйн нэр байсаар ирсэн юм"¹ гэж Симона де Бовуар хэлсэн байдаг."

Амьдрал дээр эмэгтэй хүн ямар нэг "мөн чанар"-тай зүйл биш, "эмэгтэй хүний" гэсэн ямар нэг урьдчилан тогтоогдсон константтай биш, харин нийгэмд, соёлд "эмэгтэй хүний нөхцөл байдал" гэсэн онцлог л байдаг гэдгийг тэр сайтар ойлгож байсан аж. Эмэгтэй хүн өөрт нь орчноос нь сөргүүлэн тавьж буй зүйлстэй мөргөлдөж, түүнийхээ золиос болж байснаас өөрийгөө "дагавар хүйстэн", "ондоо хүн" гэж үзэхийг сэтгэл зүйн хувьд хүлээн зөвшөөрөхөд бэлэн байдгийг Симона де Бовуар гярхай ажигласан байна. Улмаар эмэгтэй хүний оюун санаа, ухамсар бүрэлдэх үйл явцыг маш нягтлан, нэг бүрчлэн судлан шинжлэхийн тулд олон арван баримт, эх сурвалжуудыг үзсэн байдаг. "Өмнөх онолууд эмэгтэй хүний нийгмийн нөхцөл байдлыг өөрчилж, эмэгтэйг "хамаарал"-тай байдлаас чөлөөлөл тухай ярьсан бол Симона де Бовуар нийгмийн хүрээнээс хальж, бие хүний үл давтагдах бодгаль шинжийн хүрээнд асуудлыг дэвшүүлж, эмэгтэй хүний экзистенциаль

нөхцөл байдлыг бүх үе шатаар нь авч үзэхдээ: хүүхэд байхаас эхлээд нас өтөлтлөө “эмэгтэй хүн байна” гэдэг нь “хувь тавилан бус харин байгаа байдал л” юм гэдгийг илтгэн харуулсан байна. Иймээс л эмэгтэй хүн соёл дахь өөрийнхөө “нөхцөл”-ийг өөрчлөхийн тулд “эрэгтэй хүн”-ий байр суурин дээр очдог байна. Энэ тохиолдолд түүний хүмүүжил, боловсрол, үнэлэмжийн баримжаалал эрэгтэй хүнийхээс огт ялгаагүй байвал л бүрэн дүүрэн хэрэгждэг² гэж тэр дүгнэжээ.

Симона де Бовуар номынхоо нэгдүгээр ботийн “Баримтууд ба шидэт домгууд” бүлэгт 17-р зууны үеийн гуманист Пулен дэ ля Баррын хэлсэн: “... эмэгтэй хүний талаар эрэгтэйчүүдийн бичсэн бүх зүйлд эргэлзээтэй хандах ёстой. Учир нь, эрэгтэй хүн нэгэн зэрэг шүүгч, бас бидэнд шахалт дарамт үзүүлж байгаа субъект юм” гэсэн үгийг үндэслэн эмэгтэй хүний талаарх өмнөх үнэлэлт, дүгнэлтүүдэд болгоомж, шүүмжлэл бүхий хандаж, улмаар [“эмэгтэй хүн болж төрдөггүй, харин эмэгтэй хүн болдог юм”] гэсэн алдарт томъёолол гаргажээ. “Хүний биенийг олж төрнө гэдэг нь ямар хүйстэй төрөв гэдгээсээ хамаараад эсвэл “эрэгтэй хүн”-ий, эсвэл “эмэгтэй хүн”-ий нөхцөлд л ордог ажээ. Симона де Бовуарын үзсэнээр эмэгтэй хүн биологийн шинж, хүчин зүйлсийг өөртөө шууд хүлээж авдаг боловч сарын тэмдэг эсвэл жирэмслэх гэх мэтийн физиологийн үзэгдэлд хандах нийгмийн хандлагаас болоод эмэгтэй хүн “эмэгтэй биш болж харгадах” гэсэн бэрхшээлтэй тулгардаг гэнэ. Иймд түүний баримтлалд “хүйс” гэдэг бол хүний бие махбодын л шинж болохоос эмэгтэй хүний амьдралд зарчмын хувьд ач холбогдолтой зүйл биш³ юм. Дагавар хүйстэн бүтээл бол эмэгтэй хүн эрэгтэй хүнээс эдийн засаг, нийгмийн болон сэтгэл зүйн хувьд үл хамаарсан оршихуй мөн учир бие даасан “түүхийн субъект” болдог гэдгийг баталж, бүх дэлхийн эмэгтэйчүүдэд бодит эрх чөлөөнд хүрэх замыг нээжээ. Ийм болохоор “Дагавар хүйстэн” бүтээл “эмэгтэйчүүдийн библи” хэмээх алдрыг хүртсэн бизээ.

Эмэгтэй хүний өдөр тутмын амьдралд үүсдэг тулгамдсан асуудлууд болох “хэвийн”, “зөв”, “жинхэнэ” эмэгтэй хүний дүр төрхөд нийцэж байгаа эсэхээс өөрийгөө мэдрэх мэдрэмж, өөрийн үнэлгээ, эмэгтэйн хувь заяа / оршихуй/ шууд хамааралтай болсон аж. Учир нь, орчин үеийн социалист хөгжлийн замыг туулсан нийгмийн эмэгтэйчүүд бидний хувьд нийгмийн амьдралд идэвхтэй оролцож эхэлсэн үйл явц социалист нийгмийн бүтээн байгуулалтын эрин үетэй давхцаж таарснаараа онцгой сонин тохиолдол

болон хувирсан байна. Өнгөрсөн олон арван жилийн туршид социалист үзэл сурталчид юунд ч бууж өгдөггүй, эр хүнтэй "мөр зэрэгцэн" тэмцэгч эршүүд эмэгтэйн хэв маягийг сурталчилж, магтан дуулж өргөмжилсөн юм. / Гэвч эмэгтэй хүн угаасаа эр хүнтэй мөр зэрэгцэн тэмцэх хүч чадалтай төрдөггүй. Ер нь ч тэгээд ингэх ёстой юм гэж үү?/

Судлаачид социализмын үед бүрэлдэн тогтсон эмэгтэй хүний дүр төрх, загварыг харуулдаг гол эх сурвалжууд хэмээн тухайн үеийн кино, уран зохиолыг сонгож байгаа нь санамсаргүй зүйл биш юм. Учир нь, жендерийн асуудлууд, жендер судлал өөрөө постмодерн үеийн сэдэв, судалгааны үндсэн салбаруудын нэг учир постструктуралист арга зүй нь жендер судлалын арга зүй болон хөгжсөн түүхтэй. Ийм ч учраас кино судлаачид, урлаг судлаачид энэ сэдвээр илүү их хөндсөн байдаг.

Кино судлаач Лилия Мамонтова социализмын үеийн эмэгтэй хүний төлөвшил, шинж чанар, түүнд үүсдэг асуудлуудыг социализмын нийтийн соёлоос өөрөөс нь гаргаж тайлбарлахдаа "хуарангийн социализмын үзэл сурталчид нийгмийн үйлдвэрлэлд сүл хүйсийнхэн буюу эмэгтэй хүний оруулах хувь нэмрийг хэрхэн дээдэлж, магтан дуулснаар "социалист эмэгтэйн домог" бүтээгджээ⁴ гэсэн байдаг. [Тухайн үеийн социалист нийгмийн хөдөлмөрийн армийн нэг талыг эмэгтэйчүүд дангаараа бүрдүүлж байсан тэр л цаг мөчид эмансипаци /чөлөөлөлт/ явагдаж, эмэгтэйчүүдэд сонголтын эрх чөлөө олгож, дээд боловсрол эзэмших боломж бодитойгоор бүрджээ. Энэ бол "гэрийн" хүний мөнхийн мөрөөдөл биеллээ олж, тэр ч бүү хэл эмэгтэй хүн төрийн жолоо атгалцах хэмжээнд хүртлээ эрх чөлөөтэй болсон мэт байсан ч, бодит амьдрал дээр эрэгтэйчүүд ноёрхсон хэвээр, харин эмэгтэйчүүдэд үл ойлгогдох, тайлбарлахад бэрхтэй, бүр хачирхмаар дүр төрх аяндаа бий болсон аж. Өөрөөр хэлбэл эмэгтэй хүн эрэгтэй хүнтэй адил нийгмийн тэгш эрхтэй болсон ч бодит байдалд энэ нь хэрэгжих үндэс байгаагүй ажээ.]

Постструктурализм дахь текстийн анализын аргыг социалист нийгмийн эмэгтэйг судлах арга зүй болгон судлаачид сонгоходоо тухайн үеийн кино, утга зохиолыг гол эх сурвалжаа хэмээн үзсэн юм. Эмэгтэй хүн нийгэмд хамгийн ашигтай хөдөлмөр эрхлэх бололцоотой болсон ч үр дагавар нь эмэгтэй хүнд эцэстээ харин ч зайлшгүй хэрцгийлэл болон хувирч, сонголтын эрх чөлөө бодит биеллээ олоогүй ажээ. Үүсэн бий болсон бодит байдал тухайн үеийн

үзэл сурталд будагдаж, "эмэгтэй хүний эрх" нь "социалист хүний эрх" хэмээх демог болон замхарчээ. Үүнийг социализмын үеийн кино, уран зохиол, үзэл суртлаас төвөггүйхэн харж болно. Үр дүнд нь эмэгтэй хүний нийгмийн оролцоо эршүүд чанарын хэмжээгээр тодорхойлогддог гажиг систем бурэлдсэн байна. "Эмэгтэй хүний уламжлалт шинж, эрхэм нандин чанарууд болох даван туулах, тэсэж тэвчих, зөвлөн зөрүү байдал, нарийн мэдрэмжүүд нь энэ л үед бүдгэрэн замхарчээ" хэмээн Лилия Мамонтова "Машенька ба Зомби" өгүүлэлдээ хэлсэн байdag.

Гэвч социалист уралдаанд байнга тэргүүлэгч, ялан дийлэгч, тэмцэгч эмэгтэйг социализмын үеийн нийтийн соёлд бурханчлан дүрсэлсэн нь ч санамсаргүй зүйл биш байжээ. Лилия Мамонтовагийн бичсэнээр "Нисгэгчид" кинонд нисэхийн сургуулийн сонсогч Быстрова бүсгүй бүх хөвгүүдээсээ илүү сайн нисэж сурсаныг харуулдаг. Зарим кинонд барилгын салбарт сул хүйстэн хамгийн сайн шаварчин, зөөгч, өрлөгчин хийж байгааг дүрсэлсэн жишээ мундахгүй олон байдаг. "Тракторчид" кинонд чийрэг бадриун Марина Ладыгина эрэгтэй хүний комбинзон, том бахиал өмссөнөөр дүрслэгдэн үзэгчдийн ой ухаанд үлджээ. Үүнийгээ ч тэр үедээ маш хүчтэй үзэл сурталддаг байлаа.

Эмэгтэй хүний өөрийн хөгжил, эмэгтэй хүний бодит амжилтыг үйлдвэрлэлийн өсөлтийн тоон харьцаагаар илэрхийлдэг жишиг энэ үед нэгэнт тогтсон байсан юм. Тэр тусмаа эмэгтэйчүүд хүнд хэцүү мэргэжлийг төвөггүйхэн эзэмшиж, улмаар ямар амжилт үзүүлж байгааг илтгэн үзүүлдэг. Газар хагалдаг машинаар тун эвлэгхэн, түүртэлгүй ажиллаж сураад тун удалгүй илүү хүнд механизмтай трактор дээр ажиллаж сурч байгаагаар "Эргэж ирлээ" киноны Инна Бортникованг харуулдаг. Энэ төрлийн жишээнүүдийг тухайн үеийн Монголын урлагаас мундахгүй олныг нэрлэж болно. Кино урлагийн салбарт л гэхэд "Элбэг дээл", "Морьтой ч болоосой", "Нийслэл хүү", "Энэ хүүхнүүд үү", "Жаргал даахгүйн зовлон" зэрэг киноны эршүүд эмэгтэйчүүдийг нэрлэж болно.

Тэр үеийн кино үзэгчид эмэгтэй хүний баатарлаг туульсыг дэлгэцээс бахархан ширтэхдээ энэ их ачааг үүрч, даван туулснаар эмэгтэй хүнд өөрт нь ямар уршигтай ул мөр үлдэж байгааг төдийлөн анзаараагүй аж. Уг нь тэр үеийн хүүхнүүд тариан талбайд, үйлдвэрийн цехэд, барилгын талбар дээр ажиллаж байсан ч гэртээ хариад гэрийн халатаа аяндаа л өмсдөг байсан шүү

дээгэтэл дэлгэцийн үлгэр жишээ хуухнууд маань чөлөөт цагаараа гэр орондоо эр нөхрөө халамжилж, үр хүүхэдтээ хүмүүжүүлж байгаагар биш, харин үзэл суртлын тэмцэгчид болон ажиллаж байгааг кинонуудад үзүүлдэг байв. Ийм маягаар хүмүүсийн "тархийг угаасан"-аар тэдний оюун санаанд ямар их хор уршиг тарьж байсан нь ойлгомжтой бөгөөд үүнээс зайлах ч арга тэр үед байгаагүй ажээ. Энэ нь манай соёлын "хүйсийн хэвшмэд бодол"-д /стереотип/ суурь гажуудал, эвдрэлийг бий болгох хөрс суурь болжээ. Ингээд эмэгтэй хүн гойд идэвхтэй, хүдэр бадир, заримдаа бүр жаахан зуур түрэмгийлэгч болон хувирах ч энүүхэнд болсон аж. Ингэснээр эрэгтэй хүний унаган төрх ч сэвтэж, эрэгтэй хүн ямар ч идэвх зүтгэлгүй нэгэн болж дүрслэгдэж байв.]

Гэвч үзэл суртлын талбарт магтан дуулж ирсэн тийм дурийн бодит биелэл нь ердийн нэг өөрчлөлт, эсвэл зайлшгүй болох ёстой зүйл биш, харин гэр бүлийн, ахуйн, уламжлалт соёлын хөрсөнд хөнөөл учруулсан зүйл болслон юм. Улмаар нийгмийн үзэл санаа, ёс заншилд маш гүнзгий ач холбогдолтой байсан цаашид ч хадгалагдан үлдэх ёстой хүйсийн дүр байдал, зан төлөвд гарсан гажуудал нь хүмүүсийн оюун санааг өвчлүүлж, амьдралын хэв маягт нь хангалттай хэмжээний гажиг үүсгэсэн байна. Энэ гажуудал нь социализмыг туулж гарсан түүх соёлын өвөрмөц байдалтай уг сурвалжаараа гүнзгий холбоотой бөгөөд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн тэгш байдлын талаархи ойлголт нь тэднийг амьдралын маш энгийн, хялбархан, бүр ижилхэн юм шиг замд татан оруулжээ. Уг нь эрэгтэй эмэгтэй хүний амьдрал тус бүрдээ үлэмж нарийн зүйл.

[Орчин үеийн иргэншлийн нөхцөлд эрэгтэй эмэгтэй хүний хүйсийн төрөлх ялгаанаас үл хамаармал боловсрол мэргэжил эзэмшдэг тогтолцоо бүрдсэн нь бүгдэд тодорхой. Гэвч үүний үр дагаварт нь гэр бүлийн хүчин зүйл эмэгтэй хүний хувьд бодит амьдралд "нэмэлт үүрэг" буюу дагалдах шинжтэй зүйл болон хувирч байна⁵ гэж Оросын судлаачид Ю.З.Алюшина, А.С.Волович нар бичжээ.]

Манай өнөөгийн нийгэмд ч гэсэн хүйсээр зиндаархах уламжлал хүчтэй нөлөөлсөн хэвээр байна. Тийм болохоор үлэмж тохиолдолд эр хүн давуу гэсэн үзлийг урьтал болгодог хандлага хүчтэй байгаа нь мэдрэгддэг. Наад зах нь эрэгтэйчүүдийг ажилд ороход давуу эрхтэйгээр авдаг гэх мэт байдал хэт даамжирснаас эмэгтэй хүн өрсөлдегч, давуу тал олох эрмэлзэлтэй, хэт их

хүчин чармайлттай, гойд идэвхит шинжтэй эршүүд эмэгтэй болж хөгжих үндэс суурь тавигдсан гэж үзэх үндэстэй юм.

Нөгөө талаас нийгмийн боловсрол, хүмүүжлийн тогтолцоо нь бүхэлдээ нийгмийн бус идэвх гаргадаг, сул дорой, эрмэлзэлгүй субъект болох нөхцлийг хөвгүүдэд бүрдүүлж, охидын хувьд бол эсрэгээр, гойд идэвхтэй, давуу талтай байх эрмэлзэлтэй байх нөхцлийг бүрдүүлсэн ажээ.

Эмэгтэйчүүд үүссэн шинэ нөхцөл байдалдаа таарч нийцэхээс гадна "хүйсийн үүргийн талаарх стандартад ч гэсэн таарч тохирох давхар үүрэгтэй" болсныг судлаачид олонтаа дурддаг. Социологийн судалгаануудаар ч гэсэн тэдний оршихуйд бий болсон "ацалсан" шинж илэрдэг аж. Тухайлбал Оросын судлаач М.Кокарева, М.Котовская нар "Эмэгтэй хүн ба эрх чөлөө" бүтээлдээ: Орчин үед ухамсар дахь дүр зураг ба хүйс, хүсэл сонирхол ба бодит байдлын хооронд ангал үүссэн⁶ гэж дүгнэжээ. Энэ байдлыг 1997 оны зун 18-25 насны Москвагийн бүсгүйчүүдийн дунд явуулсан асуулга нотоллоо гэж дээрх хоёр судлаач өгүүлээд уг асуулгын сэтгэл зүйн тестээр бүсгүйчүүдийн 60% нь нийгмийн байр суурь болон боловсролын хувьд бие даасан, юунаас ч үл хамаарсан бие хүмүүс. Мөн уг бүсгүйчүүд сэтгэл зүйн хувьд идэвхтэй, өөрийгөө хэт өндөр үнэлсэн, өрсөлдөгч мэдрэмж хүчтэй хөгжсөн, давуу тал олох чин эрмэлзэлтэй, бусдаар өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж чаддаг, прагматик мэдрэмжтэй гэж тогтоогджээ. Бүсгүйчүүд өөрийнхөө зан төлвийг хэрхэн үнэлснийг анзаарахад 60 гаруй хувь нь өөрийгөө "жинхэнэ эмэгтэй" хүн гэж дүгнэсэн байлаа. Гэтэл асуулганд оролцсон бүсгүйчүүлийн хандлагыг үзэхэд тэд эмэгтэй хүн шиг биш харин эрчүүдийн адил авир үйлдэл бүхий хүмүүс гэдэг нь илт байжээ. Уг судалгааны үр дүнг сэтгэл зүйчдийн боловсруулсан загвараар дахин авч үзэхэд эдгээр бүсгүйчүүлд өөрийнхөө эмэгтэй хүний мөн чанарыг гаргах, илэрхийлэх бололцоо хавчигдмал байж, өөрийнх нь "унаган", "жинхэнэ" шинж дарагдсанаар тэдэнд түгшүүр, шаналгаа, итгэл алдрах байдал, цухалдал, невроз бий болсон байв. Энэ асуулгын үр дүнд нэг чухал зүйл ажиглагдаж улмаар нотлогдсон аж. Үүнд, эмэгтэйчүүдийнхээр тэдний хамгийн гол үнэлэмж бол "жинхэнэ эмэгтэй хүн" байх явдал аж. Асуулганд оролцсон 3 бүсгүй бүрийн 1 нь ингэж хариулжээ. Сонин сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг тодорхойлох судалгаагаар залуу эмэгтэй уншигчдын уншдаг үндсэн сэдэв нь "жинхэнэ эмэгтэй" хүн гэж юу болох тухай материал байдаг гэж олонтаа бичигддэг.

Ингэхлээр “жинхэнэ эмэгтэй хүн” байна гэдэг нь хүний энгийн нэг төсөөлөл, дүр зураг төдий зүйл биш, харин эмэгтэй хүний оршихуйн жинхэнэ арга хэлбэр, эмэгтэй хүний мөн чанар нь байдаг аж.

“Жинхэнэ эр хүн” “жинхэнэ эмэгтэй хүн” гэсэн үгэнд өөрт нь ямар утга санаа байдаг юм бол гэсэн асуултанд Америкийн угсаатан судлаач Нэнси Райс сонирхолтой дүгнэлт хийжээ. Тэрээр хүйсийн ялгааны талаархи ойлгоцыг “жендерийн хэвшмэл бодол” гэж нэрлээд хүйсийн нийгмийн шинж чанар бол нийгмийн үзэл бодлын үүднээс эрэгтэй эмэгтэй хүмүүс ямар шинжтэй байх ёстойг л илэрхийлдгийг анзаарсан байна. Хүйсийн хэвшмэл бодол нь соёлын гүнд нуугдмал байхдаа ердийн хэвшмэл бодол байх төдийгүй нийт хүн төрөлхтний үнэлэмжтэй, зөрчиж үл болох ойлгоцыг агуулсан байдаг болохоор “үзэл бодол” гэдэг утгаараа онцгой ач холбогдолтой зүйл юм гэжээ.¹ Н. Райс посткоммунист орнуудын эрэгтэй ба эмэгтэй хүний талаарх энгийн ойлгоц, дүр зургийг гаргахдаа “эрчүүд оюун ухаанаараа, эмэгтэйчүүд сэтгэлээрээ асуудлыг шийддэг”, “эрчүүд толгойгоороо, эмэгтэйчүүд зүрхээрээ боддог”, “эрчүүд хариуцлагагүй, бодлогогүй алхам их хийдэг, болохоор эмэгтэйчүүд тэднийг чиглүүлж байдаг”, “эрэгтэй хүн төрөлхийн завхай зайдан болохоор эмэгтэй хүн тэднийг ариун журамтай байлгах гэж маш их хүч тэвчээр тэнхээ гаргадаг”, “эр хүн хүч чадлын бэлэгдэл, эмэгтэй хүн сул доройгийн тэмдэг” гэсэн хамгийн түгээмэл тархсан жендерийн жишээнүүдийг авч үзжээ.² Хүмүүс ийм маягийн үг хэллэгийг огт ичиж зоволгүйгээр хэрэглэж, энэ үгний цаана байгаа утга санааны зөрчлийг ч үл тоомсорлодог. Жишээ нь эрэгтэй хүн төрөлхийн л ухаантай гэсэн мөртлөө хариуцлагагүй гэж тодорхойлсон нь ухаантай л бол хариуцлагатай байх ёстой гэсэн эрүүл ухааны энгийн зарчимтай нийцэхгүй байх жишээтэй. Нэг талаас томоотой, журамтай эр хүн зарим тохиолдолд найгүй архичин байхыг хүлээн зөвшөөрдгийн адилаар тайван, дөлгөөн эмэгтэй ховч яншаа авгай болон харагдах нь ч байдаг.

Эрэгтэй эмэгтэй хүний ялгааны талаар хүн бүрт өөр өөрийн гэсэн ойлголт байхын зэрэгцээ эрэгтэй эмэгтэй хүний заяамал, жинхэнэ шинжүүдийн талаар нийтлэг бүрэн дүүрэн ойлгоц ч байдгийг³ судлаачид мөн тогтоосон байна. Далан жилийн туршид ноёрхсон коммунист үзэл суртал, түүнд тохирсон боловсролын тогтолцоо, социалист реалист суртал нэвтрүүлэг нь эмэгтэй хүний тэгш эрх, тэдний нийгмийн оролцооны талаарх

асуудлыг хүмүүсийн оюун ухаанд шингээсэн шигээ түүнийг бодит амьдралд хэрэгжүүлж чадаагүй юм⁸ гэсэн "илт парадокс" гэж нэрлэсэн дүгнэлтэндээ Н. Райс хүрсэн байна. Үүнийг олон жинтэй баримтаар Н.Райс нотолсон байдаг. [Жишээ нь: Сансын анхны эмэгтэй нисгэгч Валентина Терешкова үзэл сурталчдын дайралтаас бүрэн чөлөөтэй байсан уу? гэвэл үгүй л байсан гэдэг. Түүнийг сансарт ниссэний дараахан олон арван онигоо хүмүүсийн дунд яригдаж, хэдийгээр түүнийг эмэгтэйчүүдийн тэгш эрхийг нотолж сансарт ниссэнийг албан ёсны эх сурвалжууд батлан илэрхийлж байсан ч оросууд тухайн үедээ түүнд тоомжиргүйхэн хандаж байсан гэдэг.]

Коммунист үзэл суртлын үеийн эмэгтэйчүүд нэг талаар халамжит хань, сайн ээж, нөгөө талаас социалист нийгмийн бүтээн байгуулалтанд гар бие оролцогч, хөдөлмөрчин ангийн гишүүн, гоо сайхан, орчин үеийн эмэгтэй байх ёстой байсан ажээ. Эмэгтэй хүн нийгэм дэх өөрийн хоёрдогч байр суурь, бүхнийг чаддаг хүчтэй хүйсийн талаархи хэвшмэл бодол, сэтгэл зүйн хувьд өөрийгөө дорд үзэх мэдрэмж зэргээсээ болоод эрчүүдийг бодвол өөрөөсөө хавьгүй их зүйлийг шаардаж, их хүчин чармайлт гаргаж байсан нь хэнд ч ойлгомжтой юм.

Н. Рис хүйсийн талаархи одоо байгаа хэвшмэд бодол нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль алиных нь хувьд хор уршигтай зүйл гэж үзээд "эмэгтэй хүний дээд зэргийн халамж анхаарал, хайр, гоц идэвхтэй байдал эрчүүдийг гэр бүлийн асуудал, ахуйн асуудлаар санаа тавих, гэр бүлийн хариуцлага хүлээхээс бүрэн чөлөөлжээ. Гэвч эр хүнийг хамгаалалтандаа байлагах гэсэн эмэгтэйын хүний зан төлөв өөрөөсөө хамааралтайгаар эрэгтэй хүнийг хүмүүжүүлж, улмаар эр хүн нийгмийн бусад салбарт өөрийгөө хэрэгжүүлэх, өөрийгөө үнэлэх, эр зоригтой байх, өөрийгөө хүндэтгэх, өөрийгөө мэдрэх боломжийг хаасан"⁹ гэж дүгнэжээ. Мөн тэрээр эрчүүд өөрийн мэргэжилдээ, ажилдаа өөрийнхөө хүчин чадлыг бүрэн дүүрэн дайчлах эрмэлзэлгүй, сонирхолгүй, сул дорой нэгэн болсныг онцолсон байна.

Иймд эрэгтэй хүний нийгэм дэхь эрх мэдэл жинхэнэ утгаараа хэрэгжихээ больж, эр хүн эмэгтэй хүнээс ямагт дээгүүр гэдэг хэвшмэл бодол ёс төдий болж бодол болж хувирсан ажээ. Бидний сайн мэдэх "Аман хуур" киноны Соном өвгөн эхнэр Думаадаа "чи л дандаа мэддэг шүү дээ" гэж хэлдэг кадр дээрх дүгнэлтийн нэг гэрч мөн.

Манай орны хувьд эмэгтэй хүний соёлын трансформацийн талаархи онолын судалгаа зөвхөн эхлэж байна. Харин Өрнөдийн орнуудад энэ талын судалгаа тодорхой уламжлалтай болж хэд хэд үе шат дамжин хөгжиж байна.

Тэгсгэлд нь хэлэхэд Симона де Бовуарын "үл хамаарах", "бие даасан", "чөлөөт" эмэгтэй социализмд төдийгүй Өрнөдийн нийгэмд ч жинхэнэ утгаараа хараахан биеллээ олоогүй боловч орчин үеийн дэлхий нийтийн хандлага тэр зүгт эргэлт буцалтгүйгээр чиглэснийг хэлэхэд таатай байна.]

Резюме

В нынешней нашей общественной мысли стали употребляться такие выражения и понятия как, "жендерное исследование", "равноправие полов", "социальная активность женщин" и т.д. Это в определенной мере связано с тем, что одна из главных тем философского постмодернизма – это жендерное исследование, важной ветвью которого, является философия феминизма. В её рамках западными исследователями написано много книг, основной целью которых являются ответ на такие вопросы как, например, что такое женское бытиё и в чём заключается смысл женской судьбы? Каково положение женщин в социокультурном условии? и т.д.

В данной статье показано, что в книге Симоны де Бовуар "Второй пол", являющейся теоретическим источником жендерных исследований тема смысла женского существования философична по своей сути.

Автор предпринял попытку осветить особенности некоторых проблем, которые возникают только в жизни женщин в странах постсоциалистического пространства.

Ишлэл:

1. Де Бовуар С. "Второй пол" СПб.1997. С 27
2. Г.А.Брандт. Природа женщины" Екатеринбург 200.,С 103
3. Г.А.Брандт. Природа женщины" Екатеринбург 200.,С 104
4. Л.Мамонтова. "Машенка и Зомби" Искусство кино. 1991.№6 С111
5. Проблемы усвоения ролей мужчины и женщины. Вопросы психологий 1991.№4. С.79-80
6. М.Кокарева, М.Котовская "Женщина и свобода" М.1998 С-79
7. Г.А.Брандт. Природа женщины. Екатеринбург. 2000. с.12

8. Г.А.Брандт. Природа женщины. Екатеринбург. 2000. с.13
9. Г.А.Брандт. Природа женщины. Екатеринбург. 2000. с.112

Ном зүй:

1. Ю.З.Алюшина, А.С.Волович Проблемы усвоения ролей мужчины и женщины. Вопросы психологий 1991.№4
2. Симона Дебовуар. "Второй пол". СПб. 1997
3. Г.А.Брандт. Природа женщины. Екатеринбург.2000
4. М.Кокарева, М.Котовская "Женщина и свобода" М.1998
5. Л.Мамонтова. "Машенка и Зомби" //Искусство кино. 1991.№6